# ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2017 оны 08 сарын 29 өдөр  Дугаар А/153  Улаанбаатар хот

Сургалт зохион байгуулах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.5 дахь заалт, Эрүүл мэндийн сайдын 2016 оны А/203 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтын 3.1.7, 4.7.6, 7.4.2 дахь заалт, Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/61, А/188, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн ерөнхий захирлын 2017 оны А/84 дүгээр тушаалын хоёрдугаар хавсралтын 15 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн яамнаас 2017 оныг “Нийгмийн эрүүл мэндийг дэмжих жил” болгон зарласантай холбогдуулан Нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр цуврал сургалтуудыг зохион байгуулсугай.

2. “Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэгчдийг чадавхижуулах сургагч багш бэлтгэх” сургалтын удирдамж, хөтөлбөр, зардлын төсвийг нэгдүгээр хавсралтаар батлсугай.

3. “Зорилтот бүлэгт нийгмийн эрүүл мэндийн боловсрол олгох нь” сургалтын удирдамж, хөтөлбөр, зардлын төсвийг хоёрдугаар хавсралтаар батлсугай.

4. Сургалтуудыг зохион байгуулахад шаардагдах зардлыг хавсралтын дагуу төсвийн зохих зардлаас гаргахыг Ахлах нягтлан бодогч /Д.Гантуяа/-д зөвшөөрсүгэй.

5. Сургалтын үйл ажиллагааг нэгдсэн зохицуулалтаар хангаж, үр дүнг танилцуулахыг Эрүүл мэндийн ажилтны хөгжлийн алба /З.Наранбаатар/-д үүрэг болгосугай.

6. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын баг /Ч.Баттулга/-т даалгасугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  Б.НАРАНТУЯА

420579

*Ерөнхий захирлын 2017 оны 08 дугаар сарын 29 -ны өдрийн А/153 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт*

# "НЭМ-ИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧДИЙГ БЭЛТГЭХ СУРГАГЧ БАГШ БЭЛТГЭХ" СУРГАЛТЫН УДИРДАМЖ

***Үндэслэл:***

ЭМЯ-аас 2017 оныг Нийгмийн эрүүл мэндийг дэмжих жил болгон зарласантай холбогдуулан хууль эрх зүйн орчныг сайжруулах, тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, салбарын эмч, мэргэжилтэнг сургаж чадавхижуулах, ард иргэдэд үзүүлэх нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах чиглэлээр олон ажлыг төлөвлөн хэрэгжүүлж байна. Үүний нэг нь Сингапур улсын НЭМ-ийн тогтолцоотой танилцах, суралцах чиглэлээр нийт 80 гаруй эмч, мэргэжилтэн, удирдах ажилтанг сургаж бэлтгэсэн бөгөөд уг туршлагыг нутагшуулах, орон нутгийн НЭМ-ийн мэргэжилтэнг сургаж бэлтгэх үүднээс холбогдох талууд сургалт зохион байгуулна.

Эрүүл мэндийн тухай хууль, Эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлого зэрэгт хүн амд эрүүл мэндийн тусламж үзүүлэх тэргүүлэх чиглэл нь Нийгмийн эрүүл мэндийн тусламж хэмээн тусгасан ч одоог хүртэл эмнэлгийн тусламж давамгайлж, НЭМ-ийн тусламж үзүүлэх баг, хүний нөөц бүрэн бэлтгэгдээгүй, салбарын санхүүжилтийн дийлэнхийг хэвтэн эмчлүүлэх тусламж үйлчилгээнд зарцуулсан хэвээр байгаа билээ.

Иймд бүх шатлалд НЭМ-ийн тусламж үзүүлэх чадавхыг бэхжүүлэх, эрүүл мэндийн ажилтнуудын хандлагыг өөрчлөх, НЭМ-ийн тусламжийг зохих түвшинд нь үр дүнтэй үзүүлэх нь нэн чухал байна.

***Зорилго:***

Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чиглэлээр ажиллаж буй эмч мэргэжилтнүүдэд хууль эрх зүй, НЭМ-ийн тусламж үйлчилгээний талаар шинэ мэдлэг мэдээлэл өгөх, хөгжингүй орны тэргүүн туршлагыг сурталчлах, цаашид олон нийт, эрүүл мэндийн салбарын ажилтан албан хаагчид, орон нутагтаа олж авсан мэдлэг мэдээллээ түгээн дэлгэрүүлэх, сургалт сурталчилгааны ажлыг үр дүнтэй зохион байгуулах чадварыг эзэмшүүлэх зорилгоор сургагч багшийн сургалтыг зохион байгуулж байна.

***Зорилт***:

- Нийгмийн эрүүл мэндийн тусламжийн өнөөгийн байдалтай танилцуулах;
- Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний шинэлэг мэдлэг мэдээллээр хангах;
- Гадаад сургалтад хамрагдагсдад сурган заах арга зүйн мэдлэг чадавх эзэмшүүлэх;
- Гадаад сургалтад хамрагдагсдад эрүүл мэндийн салбарын ажилтнууд болон иргэд олон нийтэд сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулах ур чадвар олгох

***Сургалт явагдах огноо:*** 2017-09-11-ээс 09-15 хүртэл

***Сургалтын үргэлжлэх хугацаа:*** 5 хоног

***Хамрагдах хүрээ:*** Нийслэлийн дүүргийн Эрүүл мэндийн нэгдлүүд, Аймгийн ЭМГ-ууд, Сум, өрхийн ЭМТ-ийн удирдлагын баг, НЭМ-ийн тусламж хүргэж буй эмч, мэргэжилтнүүдийг хамруулна.

***Зохион байгуулагч:*** ЭМХТ, АШУҮИС НЭМ-ийн сургууль

***Санхүүжилт:*** *ЭМХТ*

***Хүлээгдэж буй үр дүн:*** Иргэд олон нийтэд нийгмийн эрүүл мэндийн тусламж үзүүлэх ажлыг эрүүл мэндийн салбарын хэмжээнд амжилттай зохион байгуулах, олж авсан мэдлэг мэдээллээ түгээн дэлгэрүүлэх, салбарын бодлого шийдвэрийг бүх нэгжээр дамжуулан ард иргэдэд тэнцвэртэй хүргэх боломж нэмэгдэнэ.

## “НЭМ-ИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧДИЙГ БЭЛТГЭХ СУРГАГЧ БАГШ БЭЛТГЭХ” СУРГАЛТЫН ТӨСӨВ

| № | Зардлын нэр | Нэгж тооцоо | Төсөвлөсөн /төг/ |
|---|---|---|---|
| 1. | Бичиг хэрэг | (100*3000)*5өдөр | 1.500.000 |
| 2. | Гарын авлага | 1300*7500 | 9.750.000 |
| 3. | Цайны зардал | (100*3000*2)*5өдөр | 3.000.000 |
| 4. | Хоол | (100*14000)*5өдөр | 7.000.000 |
| 5. | Гэрчилгээ хэвлэл | 100*1000 | 100.000 |
| 6. | Заалны түрээс | | 1.000.000 |
| 7. | Баннер хэвлэх | | 300.000 |
| 8. | Багшийн ажлын хөлс/ Доктор/ | (2*20000*8цаг)*5өдөр | 1.600.000 |
| 9. | Багшийн ажлын хөлс/Магистр/ | (2*10000*8цаг)*5өдөр | 800.000 |
| | **Нийт дүн** | | **25.050.000** |

Ерөнхий захирлын 2017 оны 08 дугаар
сарын 23 -ны өдрийн А/153 дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт

# "ЗОРИЛТОТ БҮЛЭГТ НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭГ ХҮРГЭХ НЬ" СУРГАЛТЫН УДИРДАМЖ

***Үндэслэл:***

Өнөөгийн түвшинд Эрүүл мэндийн тухай хууль, Эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлого зэрэгт хүн амд эрүүл мэндийн тусламж үзүүлэх тэргүүлэх чиглэл нь Нийгмийн эрүүл мэндийн тусламж хэмээн тодорхойлсон боловч НЭМ-ийн тусламж үзүүлэх хүний нөөц дутмаг, салбарын санхүүжилтийн дийлэнх хувийг хэвтэн эмчлүүлэх тусламж үйлчилгээнд зарцуулсны улмаас хүн амыг эрүүлжүүлэх, сургалт сурталчилгааны ажил хоцрогдсоор ирсэн билээ.

ЭМЯ-аас 2017 оныг НЭМ–ийг дэмжих жил болгон зарласантай холбогдуулан хууль эрх зүйн орчныг сайжруулах, тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, салбарын эмч, мэргэжилтэнг сурган чадавхижуулах чиглэлээр олон ажлыг төлөвлөн хэрэгжүүлж байна. Салбарын хүрээнд нэгдсэн зохион байгуулалттайгаар НЭМ-ийг дэмжих жилийн хүрээнд бодлогын чанартайгаар эмч, мэргэжилтэн, удирдах ажилтанг сургаж бэлтгэх ажлыг явуулж, нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тэргүүний туршлагыг судлах, бодлогын шинэчлэлийг хийх ажлыг явуулж, ард иргэд, зорилтот бүлэгт нийгмийн эрүүл мэндийн талаар мэдээлэл хүргэх, тэднийг өвчнөөс урьдчилан сэргийлэх мэдлэг чадвартай болгох ажлыг шат дараатай зохион байгуулах шаардлага хэрэгцээ тулгамдаад байна.

Иймд зорилтот бүлэгт чиглэсэн НЭМ-ийн тусламж үйлчилгээний мэдлэг мэдээлэл олгох, цаашид эрүүл амьдралын зөв хэв заншлыг ард иргэдэд түгээн дэлгэрүүлэх ажлыг тогтмол авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

***Зорилго:***

Нийгмийн эрүүл эрүүл мэндийн тусламж үйлчилгээний онцлог, мэргэжлийн байгууллага, салбар дундын хувь оролцоо, ард иргэдэд чиглэсэн үйл ажиллагааг хэрхэн зохион байгуулах, хувь хүний хариуцлагыг өндөржүүлэх чиглэлээр хөгжингүй орны тэргүүн туршлагыг судлан, сурган заах арга зүйд мэргэшсэн эмч эмнэлгийн ажилтан, эрүүл мэндийн салбарын удирдах ажилтнуудын хүний нөөцөд тулгуурлан нийгмийн эрүүл мэндийн тусламжийг ард иргэдэд биечлэн хүргэгчид,

сургалт сурталчилгааны ажилд татан оролцуулах боломжтой олон нийт болон бүх төрлийн байгууллагын хүрээнд нийгмийн эрүүл мэндийн мэдлэг мэдээллийг түгээн дэлгэрүүлэх зорилго тавилаа.

***Зорилт***:

- Иргэдэд нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний цэгцтэй мэдлэг мэдээлэл олгох;
- Оролцогчдод олон нийтэд сургалт сурталчилгаа явуулах, зөв амьдралын хэв маягийг үлгэрлэн хэрэгжүүлэх итгэл үнэмшлийг төрүүлэх

***Сургалт явагдах огноо:*** 2017-09-18-аас 09-22 хүртэл

***Сургалтын үргэлжлэх хугацаа:*** 5 хоног

***Хамрагдах хүрээ:*** Эрүүл мэнд, боловсролын байгууллагын эмч мэргэжилтэн, нийгмийн ажилтнууд, зам тээврийн салбарын ажилтан албан хаагчид, эрүүл мэнд, нийгмийн чиглэлээр ажилладаг олон нийтийн байгууллага, ард иргэд.

***Зохион байгуулагч:*** ЭМХТ, МХОЭМ нийгэмлэг

***Санхүүжилт:*** ЭМХТ

***Хүлээгдэж буй үр дүн:*** Нийгмийн эрүүл мэндийн бодлого шийдвэрийг ард иргэдэд сурталчлан, эрүүл амьдрах, өвчнөөс урьдчилан сэргийлэх ажилд хувь хүн болон бүх шатны байгууллага, олон нийтийн оролцоо, хувь нэмрийг зорилтот бүлэгт сурталчлан таниулснаар, нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг эрүүл мэндийн салбарын хүрээнээс гаргаж, нийт ард түмний үүсгэл санаачлалын ажил болгон хэрэгжүүлэх эх суурийг тавина.

**“ЗОРИЛТОТ БҮЛЭГТ НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭГ ХҮРГЭХ НЬ” СУРГАЛТЫН ТӨСӨВ**

| № | Зардлын нэр | Нэгж тооцоо | Төсөвлөсөн /төг/ |
|---|---|---|---|
| 1. | Бичиг хэрэг | 1500*2000 | 3.000.000 |
| 2. | Гарын авлага | 1800*3200 | 5.760.000 |
| 3. | Цайны зардал | 1500*2000*2удаа | 6.000.000 |
| 4. | Хоол | 1500*6000 | 9.000.000 |
| 5. | Гэрчилгээ хэвлэл | 500*1000 | 500.000 |
| 6. | Баннер хэвлэх | | 300.000 |
| | **Нийт дүн** | | **24.560.000** |